

## **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО**

“Дорноговь аймгийн хүн амын дундах БЗДХ-ын өвчлөл-тулгамдсан асуудлууд” сэдэвт хурал-сургалтыг Дорноговь аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран 2020 оны 11 сарын 13-ны өдөр зохион байгуулав.

Дорноговь аймгийн хүн амын дунд сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байгаа БЗДХ өвчний тархалтыг бууруулах, оношлогоо эмчилгэгээг сайжруулах, хөдөө орон нутагт ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах зорилгоор Эрүүл Мэндийн Газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлэг, сумдын ЭМТ-үүд, МСҮТ-үүд, ЕБС, Боловсрол соёл урлагын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар, Уул уурхайн компаниудын эмч нарыг нэг өдрийн сургалтанд хамрууллаа.

Эмч судлаачдын бүтээлийг нэтгэн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл гаргалаа.